



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 66

Арвайхээр

Орон нутгийн өмчит компани  
байгуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.2.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Махны үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор “ӨВ ЭКО МИЙТ” компанийг байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Тус компанийн дүрмийн санг бүрдүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА



А.ИШДОРЖ